БАТЛАВ
“ЗАМ, ТӨЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ОЮУНБОЛД

“АВТО ЗАМЫН САЛБАРТ ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ТӨСВИЙН НЭР БҮХИЙ СУУРЬ НОРМУУДЫГ ШИНЭЭР НЭВТЭРЧ БУЙ ТЕХНИК ТЕХНОЛОГИД НИЙЦҮҮЛЖ САЙЖРУУЛАЛТ ХИЙХ” АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 10 сарын 06-ны өдөр № Улаанбаатар хот

1. Төсөл боловсруулах үндэслэл:	• “Авто замын норм нормативын сан”-гийн хөрөнгөөр 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө;
2. Төслөөр шийдвэрлэх асуудал:	• МУ-ын Авто замын салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй Авто зам, гүүр хоолой, арчлалт, засварын ажлын үйлдвэрлэлийн болон төсвийн нормд шүүлт хийх, шаардлагатай засвар өөрчлөлтийг оруулах • Шинээр нэвтэрч буй техник, технологийг төсвийн тооцоонд бодитоор тусгах, холбогдох төсвийн суурь нормуудыг шинэ техник, технологитой нийцүүлэн засаж сайжруулах • Төсвийн суурь нормын өөрчлөлттэй холбоотой одоо ашиглагдаж буй төсвийн программд холбогдох өөрчлөлтийг оруулах
3. Төслийн иж бүрдэл:	• Авто замын салбарт шинээр нэвтэрсэн техник, технологи, материал хийц хэсгийн ажлын зураг авалт хийх, үр дүнг боловсруулах, үйлдвэрлэлийн болон төсвийн нормыг шинэчлэн боловсруулах • Үйлдвэрлэлийн болон төсвийн нормын алдаа дутагдлыг арилгах, нэмэлт өөрчлөлтийг боловсруулахдаа шаардлагатай тохиолдолд ажлын зураг авалт хийж үр дүнг боловсруулах • Үйлдвэрлэлийн болон төсвийн нормыг албан ёсны төсвийн программ хангамжийн дата баазад оруулах, • Үйлдвэрлэлийн болон төсвийн нормын материал, авто зам, замын байгууламжийн барилга, арчлалт, засварын ажлын материалын жагсаалтыг шинэчлэх, нэгж хүнд, сийрэгжилт, хаягдал хорогдлын коэффициентыг хянаж шалгах, шаардлагатай тохиолдолд лабораторийн туршилтаар тогтоож үр дүнг төсөлд тусгах • Үйлдвэрлэлийн болон төсвийн нэр бүхий 6 нормын үндэслэл тус бүрийг дахин хянаж, шалгах, ажлын зураг авалт хийж шинээр боловсруулсан ажлыг нормын бүлэгт шинээр код үүсгэж нэмэх • Үйлдвэрлэлийн болон төсвийн нормын ажлын бүрэлдэхүүнийг технологийн дагуу хийгдсэн

	эсэхийг хянаж дутуу ажлуудыг нэмж оруулах, хаягдсан материал, машин механизмыг нэмэх • Шинэ техник, технологи үйлдвэрлэлд нэвтэрсэнтэй холбогдуулан төсвийн суурь норм болон ашиглагдаж буй төсвийн программд холбогдох өөрчлөлт оруулах • Авто зам, замын байгууламжийн ажилд шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай төсвийн суурь норм боловсруулах
4. Төслийн хүрээнд боловсруулах эцсийн үр дүн, түүний шинэлэг ба давуу тал ач холбогдол:	• Шинэ техник технологитой холбогдуулан төсвийн суурь нормыг сайжруулж өөрчлөлт оруулснаар төсөв бодитой болох, барилгын ажлын хугацаа хэмнэх, бүтээгдэхүүний үнэ буурах, чанартай бүтээгдэхүүн гарах зэрэг эерэг нөлөө үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. • Захиалагч гүйцэтгэгчийн гэрээний үнэ бодитой болж, төсвийн суурь нормын мөрдөлт, төсвийн программын хэрэглээнд эерэг нөлөө үзүүлнэ.
5. Төслийг хэрэгжүүлэх байгууллага:	• Тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий Зөвлөх баг (сонгон шалгаруулалтаар) байна.
6. Төслийг хэрэгжүүлэх хугацаа:	• 10 сар (Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш)
7. Төслийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр:	• “Авто замын норм нормативын сан”
8. Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ:	• 50,0 сая төгрөг
9. Төслийн онцгой нөхцөл:	• Судалгааны ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, боловсруулагдсан аливаа программ хангамж түүний эх код нь “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн 17.2, 18 дугаар зүйлийн дагуу захиалагч байгууллага “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын өмч болно; • Төслийн хүрээнд боловсруулсан, ашигласан бүх цахим болон хэвлэмэл материал, программ хангамж зэргийг эх хувиар эцсийн тайлангийн хамт захиалагчид хүлээлгэн өгөх; • Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага” MNS 2492:2004-ын дагуу боловсруулах; • Төслийн боловсруулалтын явцад салбарын байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, ИТА-уудаас төсөлд санал авах, саналыг тусгасан эсэх талаар тайланд хавсаргах; • Салбарын байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, ИТА-уудыг хамруулсан 2-оос доошгүй удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион

байгуулж, төсөлд санал авах; /Дунд, эцсийн шатанд/;

- Төсөлд "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирлын тушаалаар байгуулсан редакц, шүүмжийн ажлын хэсгээр шүүмж хийлгэх, мөн редакцын ажлын хэсэгтэй хамтарсан хурал хэлэлцүүлгийг зохион байгуулж хэлэлцэх;
- Редакц, шүүмжийн ажлын хэсэг эцсийн дүгнэлтийг гаргаж Зам, тээврийн яамны дэргэдэх шинжлэх ухаан технологийн дэд зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлж зөвлөмж гаргах;
- Зөвлөмжийн дагуу шаардлагатай засвар, өөрчлөлт, боловсруулалтыг хийж танилцуулгын хамт батлуулахаар Захиалагчид хүргүүлэх;
- Батлагдсан эцсийн хувилбарыг хэвлэмэл хэлбэрээр гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулан цахим хувилбар, танилцуулгын хамт Захиалагчид хүргүүлэх;
- Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх материалыг захиалагчтай хамтран бүрдүүлэх:

Хянасан:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга — Э.БАЛТ

Боловсруулсан:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын ахлах хэлтсийн мэргэжилтэн — Т.БАТБОЛД

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн мэргэжилтэн — О.ДОЛГИОН